



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 316

Улаанбаатар хот

Тогтоолын хэрэгжилтийг  
хангах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 137 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дүгээр тогтооолоор баталсан улсын төсөвт төвлөрүүлбэл зохих “МИАТ” хувьцаат компанийн 2018 оны төрийн өмчийн ногдол ашгийн өглөгийн үлдэгдэл 7,335,111,621.42 төгрөгийг чөлөөлөхөөр, 2019 оны цэвэр ашгийн дүнгээс тооцох төрийн өмчийн ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.

2. Үндэсний аудитын газрын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/24САГ-2020/0/СТА-ТШ-3 дугаар “МИАТ” хувьцаат компанид холбогдох “Орлого төвлөрүүлэх тухай” акт тавигдсантай холбогдуулан тус актыг цуцлуулж, Засгийн газрын 2020 оны 137 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх талаар Үндэсний аудитын газартай зөвшилцэн холбогдох арга хэмжээг авч ажиллахыг “МИАТ” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөрд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

3. МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000505